



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 54

Есөнбулаг сум

“Алтайн баялаг- Залуус” хөтөлбөр  
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.14, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Алтайн баялаг-Залуус” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөв, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган батлуулж, биелэлтийн явцыг жил бүрийн IV улиралд багтаан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА



Т.ГАНЗОРИГ

**"АЛТАЙН БАЯЛАГ - ЗАЛУУС" АЙМГИЙН ХӨТӨЛБӨР  
2017-2020 он**

Оюунлаг залуу хүн-Алтайн баялаг  
Хөдөлмөрч залуу хүн- Алтайн баялаг  
Эрүүл залуу хүн- Алтайн баялаг  
Оролцоотой залуу хүн- Алтайн баялаг

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Монгол улсын Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсанаар Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал эрхэлсэн төрийн байгууллагын бүтцийг шинээр бий болгож, "Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль" анх удаа батлагдлаа.

Монгол улсын "Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" бодлогын баримт бичигт "Нийгмийн хөдөлгөгч хүч- залуучууд"-ын үүрэг оролцоог илүү тусгасан байна.

Иймд шинэ үеийн залуучуудын өөрсдийн оролцоонд суурилсан бодлогыг хэрэгжүүлэх үзэл баримтлалыг чухалчлан, залуучуудын хөгжлийг дэмжих "Алтайн баялаг-залуус" хөтөлбөрийг боловсруулж байна.

Говь-Алтай аймаг нь 56694 хүн амтай. Нийт хүн амын 34.5% буюу 19331 нь 15-34 насны залуучууд байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас залуучуудад тулгамдаж буй асуудал, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зорилгоор 18 сум 2 тосгоны 18-39 хүртэлх насны залуучуудаас судалгаа авахад оролцогчдын 49,0 хувь нь залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, 43,0 хувь нь төрийн дэмжлэг, нэгдсэн бодлого хэрэгтэй байна гэж хариулсан бол 32,0 хувь нь боловсролыг чанартай, хүртээмжтэй байлгах, 30,0 хувь нь хорт зуршлыг багасгаж, эрүүл мэндийг хамгаалах, 32,0 хувь нь залуучуудын дунд эерэг хандлага төлөвшүүлэх нь чухал байна гэж үзжээ.

Нийт хүн амын дотроос хөдөлмөрийн насны 36.4 мянган хүн, үүнээс ажиллагсад 25,1 мянга, ажилгүй 2,4 мянга. ажилгүй иргэдийн 1368 буюу 56,9 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Дээрх иргэдийн 33,9 хувь буюу 816 иргэн 20-34 хүртэлх насны залуучууд байна.

***Хөдөлмөрийн зах зээлийн тоон үзүүлэлт /сүүлийн 5 жилээр/***

	2011	2012	2013	2014	2015
Хөдөлмөрийн насны хүн ам	34.4	34.0	35.2	37.1	39.1
Эдийн засгийн идэвхтэй хүн ам	23.8	23.2	25.2	26.7	27.5
Ажиллагчид	23.0	22.4	23.9	23.9	25.1
Ажилгүй иргэд	3.6	2.5	2.7	2.8	2.4

***Ажилгүйдлийн түвшин /сүүлийн 5 жилээр/***

	2011	2012	2013	2014	2015
Улсын дундаж	7.7	8.2	7.9	7.9	7.5
Баруун бүс	10.8	9.8	11.9	13.3	9.2

Говь-Алтай	10.8	13.7	10.8	10.2	8.8
------------	------	------	------	------	-----

Манай аймгийн хувьд ажилгүйдлийн түвшин улсын дунджаас их, баруун бүсийн дунджаас бага байгаа нь харагдаж байна. Эдийн засгийн идэвхтэй хүн ам, ажиллаглагчдын тоо баруун бүсдээ хамгийн бага, ажиллах хүчний оролцооны түвшин, ажилгүйдлийн түвшин хамгийн өндөр байна. Энэ нь ажил эрхлэх боломжтой ажилгүй иргэдийн тоо бусад аймгуудтай харьцуулахад өндөр байгааг харуулж байна. Ажиллах хүчний нөөц байгаа боловч ажлын байр хомс байна.

Тус аймгийн нийт залуучуудын 58,3 хувь буюу 816 нь ажил хөдөлмөр эрхэлдэггүй бөгөөд үүнээс 482 нь ажил идэвхтэй хайж аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгүүлсэн байна. /15-19 хүртэлх насны 5345 иргэнийг хасч 20-34 хүртэлх насны бүлгээр тооцсон болно./

**Ажилгүй иргэн хүйс, байршлаар**

		Бүгд	Хүйс		Байршил					
			Эр	Эм	Хот			Хөдөө		
					Бүгд	Хүйс		Бүгд	Хүйс	
						Эр	Эм		Эр	Эм
<b>Бүгд</b>		2403	1368	1035	1849	1078	771	554	290	264
<b>Нас</b>	20 - 24	378	231	147	269	195	73	109	35	74
	25 - 29	314	171	143	168	66	102	146	105	41
	30 - 34	124	62	62	124	62	62			
	35 - 39	453	173	280	265	99	166	188	74	113
	40 - 44	371	269	102	371	269	102			
	45 - 49	442	172	270	406	172	234	36		36
	50 - 54	176	145	31	139	108	31	37	37	
	55 - 59	145	145		108	108		38	38	

Ажилгүй иргэдээс 786 иргэн ажил идэвхтэй хайж Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт бүртгүүлснээс 435 нь эмэгтэй байна. Ажил идэвхтэй хайж бүртгүүлсэн иргэдийн тоог сүүлийн 5 жилээр авч үзвэл энэ үзүүлэлт өсөх хандлага ажиглагдаж байна.

Он	2011	2012	2013	2014	2015	2016
Бүртгэлтэй ажилгүйчүүд	812	847	1214	1237	981	786
Ажилгүйиргэдийн тоо	3605	2500	2895	2717	2403	2403

2016 онд ажил идэвхтэй хайж байгаа иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл 15-34 насны иргэн 429 буюу 55 хувийг эзэлж байна. Үүнээс харахад 15-34 хүртэлх насны залуучууд бусдаасаа илүү ажил хөдөлмөр эрхлэх хүсэл тэмүүлэлтэй буйг харж болох юм.

Нийт ажил хайгчдын тоо	15-24 насны иргэдийн тоо	25-34 насны иргэдийн тоо
786	435	162

Дээрх иргэдийг боловсролын түвшингээр нь авч үзвэл бүрэн дунд боловсролтой иргэд 43,5 хувь буюу 341, дипломын болон бакалаврын дээд боловсролтой иргэд 33,7 хувь буюу 265 байна. Үүнээс харахад бүрэн дунд болон дээд боловсролтой иргэд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 77,0 хувийг эзэлж байна. Дээрх үзүүлэлтийг зорилтот

бүлгээр /15-34 хүртэлх нас/ нь авч үзвэл бүрэн дунд боловсролтой 163, дипломын болон бакалаврын дээд боловсролтой 211 иргэн байна. Энэ нь нийт ажилгүй иргэдийн 47,6 хувийг эзэлж байна.

Насны бүлэг		Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын болон бакалавр	Магистр, доктор
15-60	Нийт	5	28	42	341	70	35	263	2
	Эмэгтэй	4	16	23	178	38	26	159	1
15-34	Нийт	3	11	14	175	48	20	198	1
	Эмэгтэй	2	6	5	91	29	14	129	1

Нөгөө талаас аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрийн төвд суралцаж байгаа залуучуудын судалгааг авч үзвэл 2016-2017 оны хичээлийн жилд 486 суралцагч суралцаж байна. Үүнээс:

- I курсын 7 ангид 102 оюутан суралцаг. Үүнээс эмэгтэй 35
- II курсын 9 ангид 139 оюутан суралцаг. Үүнээс эмэгтэй 78
- III курсын 8 ангид 183 оюутан суралцаг. Үүнээс эмэгтэй 93
- Мэргэжлийн сургалтын 4 ангид 62 оюутан суралцаг. Үүнээс эмэгтэй 18 байна.

2016-2017 онд барилгын цахилгаанчин, барилгын өрөгч угсрагч, барилгын засал чимэглэл, барилгын сантехникч, оёдол, талх нарийн боовны үйлвэрлэлийн технологийн ажилтан, үсчин, цахим тоног төхөөрөмжийн үйлчилгээний ажилтан зэрэг 8 мэргэжлээр суралцаж төгссөн 183 суралцагчаас ажил эрхлэлтийн судалгаа авахад өөрсдийн эзэмшсэн мэргэжлээрээ ажиллах сонирхолтой 123 суралцагч байна. Үүнээс харахад Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг төгсөж байгаа иргэдийг мэргэжлээрээ ажиллахад нь дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай байна.

Аймгийн залуучуудын дунд зонхилж буй өвчин эмгэгийн талаар мэргэжлийн байгууллагын мэдээ судалгаанаас авч үзвэл бэлгийн замаар дамжих халдварт өвчин /тэмбүү, заг хүйтэн/ 2015 онд /10,000 хүн амд/ 441.7, 2016 онд 619.2, хоол шингээх эрхтэний өвчин 2015 онд /10,000 хүн амд/ 389.7, 2016 онд 476.1, амьсгалын тогтолцооны өвчин 2015 онд /10,000 хүн амд/ 190.8, 2016 онд 247.3, осол гэмтэл 2015 онд /10,000 хүн амд/ 389.7, 2016 онд 476.1, мэдрэлийн тогтолцооны өвчлөл 2015 онд /10,000 хүн амд/ 199.8, 2016 онд 247.3 болж өмнөх оноос өссөн дүнтэй байгаа нь залуучуудын эрүүл мэндэд онцгой анхаарах, эрүүлжүүлэх, эрүүл мэндийн мэдлэгийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Иймд залуучуудыг орон нутгийн шийдвэр гаргах түвшинд оролцоог нэмэгдүүлэх, эрүүл байх, чанартай боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх боломжоор хангах, орлогоо нэмэгдүүлэх, хувийн орон байртай болгох гээд залуучуудад тулгамдаж буй нийгмийн асуудлыг шийдвэрлэж, тэднийг дэмжихэд чиглэсэн орон нутгийн бодлогыг хэрэгжүүлэх нь нэн чухал байна.

#### **ХОЁР. Хөтөлбөрийн зарчим**

- 2.1. Хөтөлбөрийн зорилго, зорилтот үйл ажиллагаа нь залуучуудын эрэлт хэрэгцээнд нийцэхүйц байх
- 2.2. Залуучуудын эрхийг дээдэлсэн, оролцоог хангасан тэгш хүртээмжтэй байх
- 2.3. Оролцогч талуудын хамтын ажиллагаа, үр ашигтай түншлэл, залуучуудын орон нутгаа хөгжүүлэх санал, санаачилгад тулгуурласан байх
- 2.4. Хөтөлбөр нь Үндэсний болон орон нутгийн бодлого хөтөлбөр, төлөвлөлт, салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоонд тулгуурлах

## ГУРАВ. Хөтөлбөрийн зорилго

Залуучууд орон нутгийнхаа хөгжил, нийгэм, эдийн засаг, соёлын амьдралд идэвхтэй оролцох, хөдөлмөрлөх орчинг бүрдүүлэн, гэр бүлийн болон нийгмийн төлөө хүлээх хариуцлагыг дээшлүүлж, бүтээлч сэтгэлгээтэй, боловсролтой, соёлтой, хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлэхэд оршино.

## ДӨРӨВ. Хөтөлбөрийн зорилт

4.1. Оюунлаг залуу хүн-Залуучуудыг мэдлэг боловсролтой, оюунлаг иргэн болгон төлөвшүүлнэ.

4.2. Хөдөлмөрч залуу хүн- Залуучуудын хөдөлмөр эрхлэх чадварыг дээшлүүлэн, бизнес эрхлэх боломжийг бүрдүүлж, ажлын байрыг бий болгоно.

4.3. Эрүүл залуу хүн- Залуучуудын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл дадал хэвшилтэй бүтээлч залуучуудыг бий болгоно.

4.4. Оролцоотой залуу хүн- Залуучуудад эерэг хандлага, зан үйлийг төлөвшүүлэн нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлнэ.

## ТАВ. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

**5.1. Оюунлаг залуу хүн-Залуучуудыг мэдлэг боловсролтой, оюунлаг иргэн болгон төлөвшүүлэх зорилтын хүрээнд:**

5.1.1. "Залуу эрдэмтэд", "Залуу багш", "Залуу эмч", "Залуу инженер" гэх мэт мэргэжилд түшиглэсэн залуучуудын сайн дурын байгууллага /клуб, зөвлөл, нэгдэл, холбоо/ байгуулах санаачлагыг дэмжиж, залуучуудад зориулсан сургалт, сурталчилгаа, сайн туршлагыг түгээх, зөвлөх үйлчилгээг нэвтрүүлнэ.

5.1.2 Залуучуудын гадаад хэлний мэдлэгийн түвшинг сайжруулах орчинг бүрдүүлэн гадаад хэлний сургалтын тоог

5.1.3. Залуучууд англи хэлний TOFEL-ийн шалгалтыг орон нутагтаа өгөх боломжийг бүрдүүлэн, танхимыг иж бүрэн тохижуулж, шалгалтын эрх авна.

5.1.4. Гадаад, дотоодын их, дээд сургуулиудад баклавар, магистр, докторын сургалтад аймгийн Засаг даргын нэрэмжит дэмжлэгийг жил бүр 5 /тав/ хүртэлх оюутанд олгоно.

5.1.5. Улс, бүс, дэлхийн хэмжээнд хичээл сургалт, урлаг, спортоор амжилт гаргасан болон гоц авьяастай, оюуны өндөр чадвартай залуучуудын оюуны бүтээлийг дэмжинэ.

5.1.6. Орчин үеийн техник, технологийг ашигласан цахим сургалтын системд хамрагдан боловсрол эзэмших, мэргэжил дээшлүүлэх боломж нөхцөлөөр хангана.

5.1.7 Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын сурч, боловсрох нөхцөлийг бүрдүүлж, хөгжлийг нь дэмжинэ.

**5.2. Хөдөлмөрч залуу хүн- Залуучуудын хөдөлмөр эрхлэх чадварыг дээшлүүлэн, бизнес эрхлэх боломжийг бүрдүүлж, ажлын байрыг бий болгох зорилтын хүрээнд:**

5.2.1. 15-39 хүртэлх насны залуучуудын судалгааг нарийвчлан гаргаж мэдээллийн сан бүрдүүлнэ.

5.2.2. Ажилгүй залуучуудыг хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэж мэдээлнэ.

5.2.3. 15-39 хүртэлх насны залуучуудыг мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх сургалтад хамруулна.

5.2.4. Эрэлттэй, нарийн мэргэжил эзэмшсэн залуучуудаа орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжоор хангана.

5.2.5. Аж ахуй эрхлэлтийн болон бизнес санаа олох, хайх, хөгжүүлэх сургалтуудыг эрх бүхий сургалтын байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

5.2.6. 15-34 хүртэлх насны залуучуудын дунд орон нутгийн хэрэгцээнд нийцсэн шинэ "Гарааны бизнес"-ийн уралдаан зохион байгуулж, шалгарсан шилдэг бизнес санааг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Орон нутгийн хөгжлийн сан, бусад төсөл хөтөлбөрүүдтэй хамтран санхүүжүүлнэ.

5.2.7. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн төгсөгчдийг эзэмшсэн мэргэжлээрээ ажиллахад нь 3,0-10,0 сая хүртэлх төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгох замаар ажлын байртай болгоно.

5.2.8. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн төгсөгчдийн дунд ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулж, ажилд зуучлах үйлчилгээнд хамруулна.

5.2.9. Зорилтот бүлгийн залуучуудад мэргэжил олгох сургалтыг зохион байгуулах, тэднийг тогтвортой ажлын байраар хангасан ажил олгогчдыг урамшуулна.

5.2.10. Гадаад, дотоодын хандивлагч болон төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран ажиллаж ажил хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлнэ.

5.2.11. Залуучуудын бизнес санааг хөгжүүлэх, сурталчлан таниулах зорилгоор телевизийн нэвтрүүлэг бэлтгэж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээнэ.

5.2.12. Орон нутгийн бүтээн байгуулалтад залуучуудыг хамруулж түр ажлын байраар ханган орлогыг нь нэмэгдүүлнэ.

5.2.13. Ахмадын зөвлөх үйлчилгээний хүрээнд хүүхэд, залууст ажлын дадлага, туршлага, мэргэжлийн ур чадварыг нь өвлүүлэх ажлыг зохион байгуулна.

**5.3. Эрүүл залуу хүн- Залуучуудын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл дадал хэвшилтэй бүтээлч залуучуудыг бий болгох зорилтын хүрээнд:**

5.3.1. Өсвөр үе, залуучуудад бэлгийн замаар дамжих халдварт өвчний хор уршиг, үр дагавар, сайн дурын үзлэг шинжилгээний ач холбогдлын талаар сургалт сурталчилгаа нөлөөллийн ажлуудыг тогтмол зохион байгуулна.

5.3.2. Эрүүл мэндийн боловсрол олгох, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургагч багш нарыг бэлтгэн, ур чадварыг дээшлүүлэх үйл ажиллагааг тасралтгүй дэмжиж, залуучуудын өмнө тулгамдаж буй асуудалд залуус, залуусдаа нөлөөлөх арга зүйг хөгжүүлнэ.

5.3.3. Залуучуудад эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, нийгмийн эрүүл мэнд, нийтийн биеийн тамирыг сурталчилсан "Эрүүл мэндийн цаг" нэвтрүүлгийг мэргэжлийн байгууллагатай хамтран бэлтгэн, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэнэ.

5.3.4. БЗДХ/ХДХВ-ийн нэр хаяггүй сайн дурын шинжилгээ, бэлгийн эрүүл мэндийн зөвлөгөө авах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

5.3.5. Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын эрүүл мэндийн тусгай хэрэгцээг хангахад нийгэм, хамт олонд түшиглэсэн нөхөн сэргээх, нийгэмшүүлэх үйлчилгээг өргөжүүлнэ.

5.3.6. Залуучуудын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх спорт заал болон алжаал тайлах, бялдаржуулах, иог, бясалгалын төв зэрэг тэдэнд ээлтэй үйлчилгээг нэвтрүүлнэ.

5.3.7. Залуучуудын өөрсдийнх нь оролцоотойгоор осол гэмтлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах нөлөөллийн ажлуудыг зохион байгуулна.

5.3.8. Залуучуудын идэвх оролцоог нэмэгдүүлэх, эерэг зан үйлийг төлөвшүүлэх, эрүүл амьдрах дадал хэвшлийг бий болгох зорилгоор майхант, дугуйн, явган, гэр бүлийн аяллуудыг зохион байгуулна.

5.3.9. Цэргийн насны залуучуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, эрүүлжүүлэх аян зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллана.

5.3.10. Өсвөр насны охидын жирэмсэлтээс сэргийлэх, тэдэнд эрүүл аж төрөх ёс, эрүүл зан үйлийг сурталчилах сургалт сурталчилгааг төр төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

5.3.11 Өсвөр үе, залуучуудын дунд вируст гепатит, элэний өвчнийг илрүүлэх үзлэгийг үе шаттайгаар зохион байгуулна.

5.4. Оролцоотой залуу хүн- Залуучуудад эерэг хандлага, зан үйлийг төлөвшүүлэн нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

5.4.1. Сайн дурын ажилтан залуучуудыг бэлтгэж залуучуудын нийгмийн бодит оролцоог нэмэгдүүлнэ.

5.4.2. Хорих байгууллагаас суллагдсан залуучуудыг ажлын байраар хангасан аж ахуйн нэгж байгууллагыг дэмжинэ.

5.4.3. Сумдын залуучуудын нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлж, тэдний хэрэгцээ шаардлагад тулгуурласан мэдээ мэдээлэл, төрийн үйлчилгээг хүргэх нөлөөллийн ажлыг сумдад зохион байгуулна.

5.4.4. Аймгийн Залуучуудын холбоо болон залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэний нийгмийн байгууллага, клуб, зөвлөлийг дэмжиж, чадавхжуулан, уялдаа холбоог сайжруулна.

5.4.5. Залуучуудын зөвлөгөөн, чуулга уулзалт, спорт, урлаг соёлын наадмыг тогтмол зохион байгуулна.

5.4.6. Залуу гэр бүл чөлөөт цагаа хамтдаа өнгөрүүлэх, амрах, алжаал тайлах таатай орчин бүрдүүлэх ажлын хүрээнд иргэний нийгмийн байгууллага клуб, зөвлөлтэй хамтран залуучуудын төгөл, гудамж, талбай зэргийг байгуулна.

5.4.7. Орон нутгийн хөгжил, бүтээн байгуулалтад хувь нэмрээ оруулж, үр бүтээлтэй ажиллаж байгаа залуучуудыг алдаршуулж, урамшуулна.

5.4.8. Улирал бүрийн сүүлийн сарын 01-ний өдрийг “Залуучуудын дуу хоолой” залуучуудыг сонсох өдөр болгон зохион байгуулж, санал бодлыг нь сонсоно.

5.4.9. Манлайлагч залуусыг бэлтгэн, тэднээр дамжуулан зөв зан үйлийг залуучуудад төлөвшүүлнэ.

5.4.10. Залуу гэр бүлийг орон сууцжуулах, хямд өртөг бүхий орон сууц худалдан авах, хөнгөлөлттэй зээл олгох санаачлагыг гаргасан байгууллагыг дэмжинэ.

5.4.11. Залуу хүн бүр үндэсний бичиг, хэл, соёл, өв уламжлал, зан заншил, ардын урлаг, уламжлалт тоглоом наадгайг өвлөх, дээдлэх, хөгжүүлэх, судлах хөдөлгөөн, аянг өрнүүлнэ.

5.4.12 Гэмт хэрэгт өртөж, нийгмээс тусгаарлагдсан залуучуудад амьдрах ур чадвар, аж төрөх ухааны сургалт, сэтгэл зүй, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх хөтөлбөрт үйлчилгээг нэвтрүүлнэ.

### **ЗУРГАА. Хамрах хүрээ**

6.1 Говь-Алтай аймгийн 15-39 насны залуучууд

6.2 Залуучуудын сайн дурын байгууллага, сонирхлын бүлгүүд

### **ДОЛОО. Удирдлага, зохион байгуулалт**

7.1 Аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, төрийн болон төрийн бус залуучуудын байгууллага, нэгдэл, клуб, зөвлөл, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл оролцсон хөтөлбөр хэрэгжүүлэх зөвлөлийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулна.

7.2 Хөтөлбөр хэрэгжүүлэх зөвлөл нь нэгдсэн төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийн тайланг нэгтгэж, хагас, бүтэн жилээр аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсээр хэлэлцүүлж, аймгийн Засаг даргын зөвлөл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил бүр тайлагнана.

7.3 Төслийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн үнэлгээг хагас, бүтэн жилээр аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс хийж, танилцуулна.

7.4 Төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлд өгсөн үнэлгээ, дүгнэлтийг үндэслэн зөвлөмж гаргаж, цаашдын үйл ажиллагаанд тусгаж ажиллана.

7.5 Хөтөлбөр нь орон нутгийн Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн болон төрийн бус байгууллага, сайн дурын үүсгэл санаачлагын байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагуудын хамтын ажиллаганы хүрээнд хэрэгжих бөгөөд холбогдох байгууллагууд хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд гарч буй ололт амжилт, ахиц өөрчлөлт, үр дүнг олон нийтэд мэдээлэх, сурталчлах үйл ажиллагааг ил тод, нээлттэй зохион байгуулна.

7.6 Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, жил бүрийн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлнэ.

7.7 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх мэдээ, тайланг аймгийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан олон нийтэд, ил тод, нээлттэй мэдээлнэ.

#### НАЙМ. Хөтөлбөрийн санхүүжилт

- Орон нутгийн хөгжлийн сан
- Сум хөгжүүлэх сан
- Улс, орон нутгийн төсөв
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
- Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн дэмжлэг
- Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл
- Бусад эх үүсвэр

#### ЕС. Хөтөлбөр хэрэгжих хугацаа

9.1 Нэгдүгээр үе шат 2017-2018 он

9.2 Хоёрдугаар үе шат 2019-2020 он

#### АРАВ. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг дараах хэмжүүрээр үнэлнэ.

№	Хөтөлбөрийн хэрэгжүүлэх зорилтууд болон шалгуур үзүүлэлтүүд	Суурь үзүүлэлт 2016он	Хүрэх түвшин	
			2017-2018 он	2019-2020 он
1	Зорилтот сургалтанд хамрагдах залуучуудын тоо /18-39 нас/	350	Жил бүр 500-аас доошгүй	Жил бүр 500-аас доошгүй
2	Нөлөөллийн үйл ажиллагаанд хамрагдах залуучуудын тоо /18-39 нас/	5000	Жил бүр 10000-аас доошгүй	Жил бүр 10000-аас доошгүй
3	Бэлтгэгдсэн сургагч багшийн тоо	0	25	25
4	Сайн дурын ажилтан залуусын тоо	0	50	200
5	Залуучуудын халдварт өвчний тохиолдлын хувь /18-39 насны хооронд/	10000 хүн амд 146,1	30% бууруулна.	50% бууруулна
6	Залуучуудын зөвлөлийн тоо	4	Бүх сумдад байгуулна.	
7	В, С вирусийн шинжилгээнд хамрагдсан тоо		95%	-
8	В, С вирусийн эмчилгээнд хамрагдсан тоо		50%	90%



9	Start-up арга хэмжээний тоо	0	4	4	
10	Start-up арга хэмжээний хүрээнд дэмжлэг авсан бүлгийн тоо	0	8	8	
11	Хөтөлбөрийн хүрээнд бий болсон ажлын байрны тоо	Start-up	0	20	20
		МСҮТ төгсөгч	0	10	10
12	Залуучуудыг байнгын ажлын байраар хангаж, урамшуулалд хамрагдах ажил олгогчийн тоо	-	5-аас доошгүй	5-аас доошгүй	
13	Аж ахуй эрхлэлтийн болон бизнесийн сургалтанд хамрагдсан залуучуудын тоо	100	100	100	
14	Залуучуудын хандлагыг өөрчлөх үйлчилгээнд хамрагдсан хүний тоо	50	150	300	
	Залуучуудын чуулган, урлаг спортын нэгдсэн арга хэмжээ зохион байгуулсан тоо	0	3	3	

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны  
05 дугаар сарын 31-ний өдрийн 54 дүгээр  
тогтоолын 4-р хавсралт

"АЛТАЙН БАЯЛАГ - ЗАЛУУС" хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт		УТөсөв	Санхүүжилтийн эх үүсвэр /Мян төг/			Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	
		Хэмжих нэгж	Хүрэх үр дүн		ОНХС	ХЭДС	Төсөл хөт		Үндсэн	Хамтрагч
<b>Зорилт 1. Оюунлаг залуу хүн-Алтайн баялаг</b>										
1	"Залуу эрдэмтэд" "Залуу багш", "Залуу эмч", "Залуу инженер" гэх зэрэг мэргэжилд түшиглэсэн үйл ажиллагаа	Байгуулсан ИНБ-ын тоо, нэгдсэн залуучуудын тоо	Залуучуудын идэвх оролцоо, мэдлэг дээшилнэ.	2000,0	4000,0	-	Жил бүр 1000,0	2017-2020 он	ГБХЗХГ	Сумын ЗДТГ БСУГ Залуучуудын холбоо
2	Сайн дурын ажилтан залуусыг бэлтгэх	Бэлтгэсэн залуусын тоо	Залуучуудын бодит оролцоо нэмэгдэнэ.	1000,0	1000,0	-	-	2018 онд	ГБХЗХГ	АЗДТГ
3	Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын сурч, боловсрох нөхцөлийг бүрдүүлж, хөгжлийг нь дэмжинэ.	Тусгай хэрэгцээт залуучуудын тоо	Тусгай хэрэгцээт залуучуудын боловсрол, хөгжих орчин нөхцөл сайжирна.	-	10000,0	-	10000,0	2017-2019	ГБХЗХГ	Залуучуудын холбоо Сумдын ЗДТГ
4	Гадаад, дотоодын их, дээд сургуулиудад бакалавр, магистр, докторын сургалтад аймгийн Засаг даргын нэрэмжит дэмжлэг	Хамрагдсан залуучуудын тоо	20 доошгүй залуучууд дэмжлэг авсан байна.	-	Жил бүр 5000,0	-	-	2017-2020	ГБХЗХГ	Аймаг, сумдын ЗДТГ,
5	Орон нутгийн хөгжил, бүтээн байгуулалтад хувь нэмрээ оруулж, үр бүтээлтэй ажиллаж байгаа залуучуудыг алдаршуулах	Залуучуудын тоо	Залуучуудын нийгмийн идэвх оролцоо сайжирна.	-	Жил бүр 500,0	-	-	2017-2020	ГБХЗХГ	Аймаг, сумдын ЗДТГ, Залуучуудын холбоо
6	Орчин үеийн техник, технологийг ашигласан цахим сургалтын системд хамрагдан боловсрол эзэмших, мэргэжил дээшлүүлэх боломж нөхцөлөөр хангана.	Сургалтын орчин бүрдүүлсэн байдал	Сургалтын орчин бүрдсэн байна.	5000,0	-	-	5000,0	2017-2020	ГБХЗХГ	Аймаг, сумдын ЗДТГ,
<b>2. Хөдөлмөрч залуу хүн- Алтайн баялаг</b>										

1	15-39 хүртэлх насны залуучуудын судалгааг нарийвчлан гаргаж мэдээллийн сан бүрдүүлнэ.	Судалгааны тоо	Судалгааны сантай болно	-	-	-	-	2017	ХХҮГ	Сумдын ЗДТГ
2	Ажилгүй залуучуудыг хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэж мэдээлнэ.	Бүртгэл мэдээллийн сан бүрдсэн байдал	Бүртгэл мэдээлэл сайжирна	-	-	-	-	2017	ХХҮГ	-
3	15-39 хүртэлх насны залуучуудыг мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх сургалтанд хамруулна.	Хамрагдсан залуучуудын тоо	Мэргэжлээ зөв сонгоход тусалсан байна	-	-	2500,0	-	2017	ХХҮГ	Сумдын ЗДТГ
4	Аж ахуй эрхлэлтийн болон бизнес санаа олох, хайх, хөгжүүлэх сургалтуудыг эрх бүхий сургалтын байгууллагуудтай хамтран зохион байгуулна.	Сургалтанд хамрагдсан иргэдийн тоо	Аж ахуй эрхлэгчдийн тоо нэмэгдсэн байна.	-	-	1500,0	1500,0	2017	ХХҮГ	Сургалтын төвүүд
5	15-34 хүртэлх насны залуучуудын дунд орон нутгийн хэрэгцээнд нийцсэн шинэ "Гарааны бизнес"-ийн уралдаан зохион байгуулах	Шалгарсан төслийн тоо Дэмжсэн мөнгөн дүн	Залуучуудын гарааны бизнес эрхлэлт нэмэгдсэн байна.	-	10000,0	10000,0	20000,0	2017-2020	ХХҮГ	АЗДТГ Залуучуудын холбоо
6	МСҮТ-ийн төгсөгчдийг эзэмшсэн мэргэжлээрээ ажиллахад нь 3,0-10,0 сая хүртлэх төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгох замаар ажлын байртай болгоно.	Дэмжлэг авсан залуучуудын тоо	Ажлын байр нэмэгдсэн байна	-	-	30000,0	-	2017	ХХҮГ	АЗДТГ МСҮТ
7	МСҮТ-ийн төгсөгчдийн дунд ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулж ажилд зуучлах үйлчилгээнд хамруулна.	Уралдаанд оролцсон залуучуудын тоо	МСҮТ төгсөгчид ажлын байраар хангагдана	-	-	-	-	2017	ХХҮГ	АЗДТГ МСҮТ Залуучуудын холбоо
8	Зорилтот бүлгийн залуучуудад мэргэжил олгох сургалтыг зохион байгуулах, тэднийг тогтвортой ажлын байраар хангасан ажил олгогчдыг урамшуулна.	Сургалтын тоо, хамрагдсан иргэдийн тоо	Зорилтот бүлгийн залуус ажлын байртай болсон байна.	-	-	14400,0	-	2017	ХХҮГ	Залуучуудын холбоо
9	Гадаад болон дотоодын хандивлагч байгууллагууд, төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран ажиллаж ажил хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлнэ.	Дэмжлэг иргэдийн тоо	Ажлын байр нэмэгдсэн байна	-	10000,0	20000,0	-	2017	ХХҮГ	Залуучуудын холбоо

10	Залуучуудын бизнес санааг хөгжүүлэх, сурталчлан таниулах зорилгоор телевизийн нэвтрүүлэг хийж хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээнэ.	Нэвтрүүлгийн тоо	Сурталчилгаа мэдээлэл сайжирна.	-	-	2500,0	-	2017	ХХҮГ	Залуучуудын холбоо Орон нутгийн телевизүүд
11	Орон нутгийн бүтээн байгуулалтанд залуучуудыг оролцуулж түр ажлын байраар ханган орлогыг нь нэмэгдүүлнэ.	Хамрагдсан залуучуудын тоо	Залуучуудын орлого нэмэгдсэн байна.	-	-	4800,0	-	2017	ХХҮГ	Залуучуудын холбоо
12	Ахмадын зөвлөх үйлчилгээний хүрээнд хүүхэд, залууст ажлын дадлага, туршлага, мэргэжлийн ур чадварыг нь өвлүүлэх ажлыг зохион байгуулна.	Зохион байгуулсан ажлын тоо	Залуучуудын мэдлэг туршлага сайжирна.	-	-	-	-	2017 онд	ХХҮГ	Залуучуудын холбоо
13	Эрэлттэй, нарийн мэргэжил эзэмшсэн залуучуудаа орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжоор хангах	Хамрагдсан залуучуудын тоо	Ажиллах нөхцөл боломж сайжирсан байна	-	-	-	-	2017 онд	ХХҮГ	ЗДТГ Залуучуудын холбоо
14	"Алтайн баялаг залуус" уулзалт, өдөрлөгийг Улаанбаатар хотод зохион байгуулах	Хамрагдсан залуучуудын тоо	Залуучууд ажлын байраар хангагдах мэдээллийн солилцоо бий болно.	-	2500,0	1000,0	-	2018 онд	ХХҮГ	ЗДТГ Залуучуудын холбоо, ТББ

**Зорилт 3: Эрүүл залуу хүн-Алтайн баялаг**

1	Өсвөр үе, залуучуудыг ДОХ, БЗДХӨ-өөс урьдчилан сэргийлэх ажлууд зохион байгуулна.	Ажлын тоо Сурталчилгааны тоо	Залуучууд эерэг хандлага төлөвшсөн байна.	6000,0	1000,0	-	4000,0	2017-2018	ЭМГ	ГБХЗХГ, Залуучуудын холбоо
2	Эрүүл мэндийн боловсрол олгох, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургагч багш нарыг бэлтгэнэ.	Сургагч багшийн тоо Ажлын тоо	Залуучуудын эрүүл мэндийн болосрол дээшилсэн байна.	5000,0	-	-	4000,0	2017-2018	ЭМГ	ГБХЗХГ, Залуучуудын холбоо
3	Залуучуудад эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, нийгмийн эрүүл мэнд, нийтийн биеийн тамирыг сурталчилсан "Эрүүл мэндийн цаг" нэвтрүүлгийг бэлтгэн олон нийтэд хүргэнэ.	Нэвтрүүлгийн тоо	Зорилтот нэвтрүүлэгтэй болсон байна.	3000,0	-	-	1000,0	2017-2018	ГБХЗХГ	Залуучуудын холбоо
4	Хөгжлийн бэрхшээлтэй	Үйлчилгээни	Нөхөн сэргээх	2000,0	-	-	2000,0	2017-2020	ЭМГ	ГБХЗХГ

	залуучуудын эрүүл мэндийн тусгай хэрэгцээг хангахад нийгэм, хамт олонд түшиглэсэн нөхөн сэргээх, нийгэмшүүлэх үйлчилгээг өргөжүүлнэ.	й тоо Ажлын тоо	үйлчилгээний чанар хүртээмж сайжирна.							Залуучуудын холбоо
5	Залуучуудын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх спорт заал болон алжаал тайлах, бялдаржуулах, иог, бясалгалын төв зэрэг тэдэнд ээлтэй үйлчилгээг нэвтрүүлнэ.	Үйлчилгээний тоо Хамрагдсан иргэдийн тоо	Залуучуудад зориулсан үйлчилгээний тоо нэмэгдсэн байна.	4000,0	10000,0	-	2000,0	2017-2020	ГБХЗХГ	Залуучуудын холбоо
6	БЗДХ/ХДХВ-ийн нэр хаяггүй сайн дурын шинжилгээ, бэлгийн эрүүл мэндийн зөвлөгөө авах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Хамрагдсан иргэдийн тоо	Бэлгийн замын халдварт өвчний илрүүлэлт нэмэгдэж, өвчлөл буурсан байна.	1000,0	1000,0	-	5000,0	2017-2020	ЭМГ	ГБХЗХГ Залуучуудын холбоо
7	Залуучуудад осол гэмтлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах чиглэлээр мэдлэг олгох сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.	Зохион байгуулсан сургалтын тоо	Залуучуудын осол гэмтлээс урьдчилан сэргийлэх мэдлэгтэй болсон байна.	1000,0	-	-	5000,0	2017-2020	ГБХЗХГ	ЭМГ Залуучуудын холбоо ЗХТ
8	Залуучуудын майхант, дугуйн, явган, гэр бүлийн аяллуудыг зохион байгуулна.	Зохион байгуулсан ажлын тоо Хамрагдсан иргэдийн тоо	Залуучуудын идэвх оролцоо нэмэгдэж, эерэг зан үйл төлөвшинө.	-	-	-	3000,0	2017-2020	ГБХЗХГ	Залуучуудын холбоо ЗХТ

#### 4. Оролцоотой залуу хүн-Алтайн баялаг

1	Гэмт хэрэгт өртөж, нийгмээс тусгаарлагдсан залуучуудад амьдрах ур чадвар, аж төрөх ухааны сургалт, сэтгэл зүй, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх хөтөлбөрт үйлчилгээг нэвтрүүлнэ.	Ажил үйлчилгээний тоо	Эерэг хандлага төлөвшсөн байна.	2000,0	-	-	1000,0	2017-2020	ГБХЗХГ	Цагдаагийн газар ШШГА Залуучуудын холбоо
2	Хорих байгууллагаас суллагдахад ажлын байраар хангасан аж ахуйн нэгж байгууллагыг дэмжинэ.	Ажлын байрны тоо	Нийгэмд эзлэх байр суурь нэмэгдсэн байна.	-	-	-	-	2017-2020	ХХҮГ	ГБХЗХГ Залуучуудын холбоо
3	Сумын залуучуудын нийгмийн идэвх оролцоог	Зохион байгуулсан	Сумдын залуучуудын	1000,0	6000,0	-	3000,0	2017-2020	ГБХЗХГ	Сумдын залуучуудын холбоо

	нэмэгдүүлж, тэдний хэрэгцээ шаардлагад тулгуурласан мэдээ мэдээлэл, төрийн үйлчилгээг хүргэх нөлөөллийн ажлыг сумдад зохион байгуулна.	ажлын тоо	оролцоо нэмэгдсэн байна.							дын зөвлөл, Залуучуудын холбоо
4	Аймгийн залуучуудын холбооны болон залуучуудын иргэний нийгмийн байгууллага клуб, зөвлөлийн үйл ажиллагааг дэмжиж, чадавхижуулан, уялдаа холбоог сайжруулна.	Хамтрагч байгууллагын тоо	Хамтын ажиллагаа сайжирсан байна	-	10000,0	-	2500,0	2017-2020	ГБХЗХГ	Залуучуудын холбоо
5	Залуучуудын зөвлөгөөн, чуулга уулзалт, спорт, урлаг соёлын наадмыг зохион байгуулна.	Зохион байгуулсан наадам, оролцогчдын тоо	Залуучуудын хөгжил оролцоо, идэвхи санаачлага нэмэгдсэн байна.	-	30000,0	-	4000,0	2017-2020	ГБХЗХГ	АЗДТГ БТСГ Алтай чуулга Залуучуудын холбоо
6	Залуу гэр бүл чөлөөт цагаа хамтдаа өнгөрүүлэх, амрах, алжаал тайлах таатай орчинг бүрдүүлэн иргэний нийгмийн байгууллага клуб, зөвлөлтэй хамтран залуусын төгөл, гудамж, талбайг байгуулна.	Хөрөнгө оруулалтын дүн	Залуучуудын оролцоотойгоор орчин бий болсон байна.	5000,0	20000,0	-	5000,0	2018-2019	ГБХЗХГ	Залуучуудын холбоо
7	Улс, бүс, дэлхийн хэмжээнд хичээл сургалт, урлаг, спортоор амжилт гаргасан болон гоц авьяастай, оюуны өндөр чадвартай залуучуудын оюуны бүтээлийг дэмжинэ.	Бүтээлийн тоо	Залуучуудыг амжилт гаргахад нь дэмжсэн байна.	-	4000,0	-	-	2017-2020	ГБХЗХГ	Залуучуудын холбоо
8	Улирал бүрийн сүүлийн сарын 01-ний өдрийг "Залуучуудын дуу хоолой" залуучуудыг сонсох өдөр болгон зохион байгуулж, санал бодлыг нь сонсоно.	Оролцогчдын тоо	Залуучуудын санал санаачилга оролцоо нэмэгдсэн байна	1000,0	-	-	1000,0	2017-2020	ГБХЗХГ	Залуучуудын холбоо
9	Манлайлагч залуусыг бэлтгэн тэднээр дамжуулан зөв зан үйлийг залуучуудад төлөвшүүлнэ.	Манлайлагч залуучуудын тоо	Залуучуудын манлайлал нэмэгдсэн байна.	-	6000,0	-	2000,0	2017-2020	ГБХЗХГ	Залуучуудын холбоо ХХҮГ
10	Залуу гэр бүлийг орон сууцжуулах, хямд өртөг бүхий орон сууц худалдан авах, хөнгөлөлттэй зээл олгох санаачлагыг гаргасан	Орон сууцтай болсон өрхийн тоо	Амьдрах орчин нөхцөл сайжирсан байна.	-	-	-	-	2017-2020	ГБХЗХГ ГХБХБГ	Залуучуудын холбоо ХХҮГ

	байгууллагыг дэмжинэ.									
11	Залуу хүн бүр үндэсний бичиг, хэл, соёл, өв уламжлал, зан заншил, ардын урлаг, уламжлалт тоглоом наадгайг өвлөх, дээдлэх, хөгжүүлэх, судлах хөдөлгөөн, аянг өрнүүлнэ.	Ажлын тоо Залуучууды нтоо	Үндэсний өв уламжлал, зан заншил, соёлд суралцсан байна.	6000,0	-	-	3000,0	2017-2018	ГБХЗХГ	Аймаг, сумдын ЗДТГ, Залуучуудын холбоо
	Нийт дүн			45000,0	148000,0	86700,0	88000,0			

-----oOo-----

КБ.

**АЙМГИЙН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНААР  
ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2017.06.19

№09

Алтай хот

№	Хэлэлцэх асуудал	Хэн хэлэлцүүлэх	Хэн байлцах	Гарах шийдвэр
1	Нэрэмжит болгох тухай /Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 304 дүгээр тусгай салбарыг Партизан С.Зандангийн нэрэмжит болгох тухай/	Г.Баасанцог	-	Тогтоол 55
2	Аймгийн баяр наадам зохион байгуулах хороо, салбар хороо байгуулах тухай	Ч.Бат-Эрдэнэ	М.Эрдэнэбилэг	Тогтоол 56
3	Аймгийн Орон нутгийн өмчийн 2016 оны дүнгийн тухай	З.Мөнхнасан	Мэргэжилтнүүд	Тогтоол 57
4	Хөрөнгө акталж данснаас хасах, акталсан хөрөнгийг үнэ тогтоон худалдан борлуулахыг зөвшөөрөх тухай	З.Мөнхнасан	Мэргэжилтнүүд	Тогтоол 58
5	Хөрөнгө балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрөх тухай	З.Мөнхнасан	Мэргэжилтнүүд	Тогтоол 59
6	Хувьчлах хөрөнгийн жагсаалтад өөрчлөлт оруулж, хөрөнгө данснаас хасах, үнэ тогтоон худалдан борлуулах тухай	З.Мөнхнасан	Мэргэжилтнүүд	Тогтоол 60
7	Төрийн дээд шагналд тодорхойлох тухай	Б.Алтайбаатар		Тогтоол 61
8	Хөтөлбөр батлах тухай	М.Мянганбуу	М.Эрдэнэбилэг	Тогтоол 62
9	Санал өгөх тухай /Бигэр сумын Булаг, Цогт сумын Өргөн нэртэй талбайд хайгуулын лиценз хүссэн өргөдөлд санал өгөх тухай/	П.Баасан	Д.Наянбуу	Тогтоол 63

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
АЖЛЫН АЛБА**